



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.25 № 388
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ

1110400388



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Т.Сарантуяа

Нийслэлийн аудитын
газрын дэд дарга
өрөөний утас:327734

Ц.Хосжаргал

Санхүүгийн аудитын
менежер
өрөөний утас:315558

Н.Баттогоо

Аудитор
өрөөний утас:325093

ТАБ-ын хаяг: Нийслэлийн
аудитын газар

Байршил: Улаанбаатар
хот Сүхбаатар дүүрэг,
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,

Нийслэлийн засаг
захиргааны V байр

E mail: ub@audit.mn

Вэб: www.city.audit.mn

Аудитын тайлан

Агуулга

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 3: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудитлагдсан төсвийн

гүйцэтгэлийн тайлан

2015 оны 3 дугаар сарын 24

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-АХ/2015/-СА-II-3-27/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 2 дугаар сарын 25-наас 2015 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын СА-ын II албаны III багийн аудитор Н.Баттогоо 2015 оны 2 дугаар сарын 25-наас 3 дугаар сарын 17-ны хооронд хийж гүйцэтгэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 1 дүгээр сарын 25-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлэв.

Аудитын тайлан, гэрчилгээг 2015 оны 3 дугаар сарын 25-нд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлагад хүргүүлэв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын зорилгыг “*аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж, аялал жуулчлалын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хотын аялал жуулчлалын нөөцийг эргэлтэнд оруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтарч ажиллах, олон улсын байгууллагын дэмжлэгээр аялал жуулчлал хөгжүүлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх замаар хотын байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд тухайн салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх*” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “*Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна*” гэж заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны төсвийг Нийслэлийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой зарим хууль, журам, зааврын хэрэгжилт зарим талаар хангалтгүй байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатны ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн. Уг бодлогын баримт бичигтэй бүртгэлийн програм уялдсан байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэлийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн захирагч нь 2014 онд нийслэлийн төсвөөс урсгал зардалд 218,146.5 мянган төгрөг батлагдсанаас 215,545.3 мянган төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн үлдэгдэл 2,601.2 мянга, өөрийн орлого 25.0 мянга, эхний үлдэгдэл 1.0 мянга нийт 2,627.2 мянган төгрөг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр Соёл спорт аялал жуулчлалын яамнаас 30,000.0 мянга, урьд оны хэмнэлт 1,012.3 мянга, Нийслэлийн Засаг даргын нөөц сангаас 130,575.9 мянган төгрөгийн орлого орсоныг зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллага нь shilendans.gov.mn сайтад өөрийн нууц үгээр нэвтэрч байгууллагын 2015 оны төсөв, 2 дүгээр сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Бэлэн мөнгөний урьдчилгаа тайлан гаргуулж, тооцоо бодоогүй, зардал хооронд гүйлгэн зарцуулсан, шатахууны лимит хэтрүүлэн зарцуулсан зөрчлүүд нь

санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь төсвийг үр ашиггүй зарцуулж зардал өсгөх, тайлан мэдээ буруу гаргах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн захирагч байгууллагын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 218,146.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, тээвэр шатахуун, гэрэл цахилгаан зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 40.0 хувь, зардлын 60.0 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Дээлтэй монгол-2014 наадам зохион байгуулахад зарцуулсан 4,500.0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний урьдчилгаа тайлан гаргуулж, тооцоо бодоогүй зардалд шууд тусгасан нь НББ-ийн тухай хуулийн 20.1.7. "анхан шатны баримт бүрдүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй байх" заалтыг зөрчсөн.

○ **Шийдвэрлэсэн:** Зөрчлийг хүлээн зөвшөөрч бэлэн мөнгөний гүйлгээ хийхдээ урьдчилгаа тайланг гаргуулж хэвших, зарцуулалтыг хянаж байх зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

2. Шуудан холбооны зардалд бусад урсгал зардлаас 792.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 147 тоот "Төсвийн хэмнэлтийн горимд шилжих зарим арга хэмжээний тухай" тогтоолын 3.2 "улсын төсвийн татаас, орон нутгийн төсвийн урсгал зардлыг 20-иос доошгүй хувиар бууруулах;" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

○ **Шийдвэрлэсэн:** Зөрчлийг хүлээн зөвшөөрч, төсвийн хэмнэлтийн горимыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу ажиллахаа илэрхийлсэн.

3. Тээвэр шатахууны зардлын лимитийг 138.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн, ажлын бус цагаар суудлын автомашин ашигласаны илүү цагийн хөлс 956.3 мянган төгрөг зарцуулсан нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/480 тоот "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" захирамжийн 2. "Албан ажлын хэрэгцээний автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 50 км-ээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тогтоосугай" заалтыг зөрчсөн байна.

○ **Шийдвэрлэсэн:** Аялал жуулчлалын газрын даргын 2015.03.19-ны 84 тоот албан бичгээр ирүүлсэн менежментийн захидлыг авч үзээд ажлын бус цагаар автомашин унасны илүү цагийн төлбөрт тогтоосон 956.3 мянган

төгрөгийг актыг хасч, лимит хэтрүүлэн зарцуулсан 138.5 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс гарсан 5,430.5 мянган төгрөгийн залруулах боломжгүй алдаа байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад үндсэн хөрөнгийг гүйцээж мөшгин шалгаж амжаагүй болно.

Аудитын явцад үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд биет тест хэрэгжүүлж амжаагүй тул хөрөнгийн үлдэгдэл болон аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг залруулсан эсэхийг завсрын аудитаар шалгахаар тогтов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,430.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 138.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх акт тавьж 5,292.0 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 5 хуудас, менежментийн захидал 4 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

**ДЭД ДАРГА
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР**

**Т.САРАНТУЯА
Ц.ХОСЖАРГАЛ
Н.БАТТОГОО**

БЭЛТГЭСЭН:

2015.03.24



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Мөнгөн хөрөнгө.....3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Зардал.....3-4

2015 оны 3 дугаар сар 18

Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн Аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №1

НАГ-ын ажиглалт

Дээлтэй монгол-2014 наадам зохион байгуулахад зарцуулсан 4,500.0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний урьдчилгаа тайлан гаргуулж, тооцоо бодоогүй зардалд шууд тусгасан нь НББ-ийн тухай хуулийн 20.1.7. "анхан шатны баримт бүрдүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй байх" заалтыг зөрчсөн

Эрсдэлүүд

Мөнгөн хөрөнгө шамшигдах, зардал буруу илэрхийлэгдэх

НАГ-ын зөвлөмж

Бэлэн мөнгөний гүйлгээ хийхдээ урьдчилгаа тайланг гаргуулж хэвших зарцуулалтыг хянаж байх зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн захирагчийн хариу

2015 оны 3 дугаар сарын 19-ны 84 тоот албан бичгээр зөвлөмж хэрэгжүүлэхээ ирүүлсэн.

Асуудал 1: Зардал

Тэргүүлэх ач холбогдол №2

НАГ-ын ажиглалт

Шуудан холбооны зардалд бусад урсгал зардлаас 792.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 147 тоот "Төсвийн хэмнэлтийн горимд шилжих зарим арга хэмжээний тухай" тогтоолын 3.2 " улсын төсвийн татаас, орон нутгийн төсвийн урсгал зардлыг 20-иос доошгүй хувиар бууруулах;" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тээвэр шатахууны зардлын лимитийг 138.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн, ажлын бус цагаар суудлын автомашин ашигласаны илүү цагийн хөлс 956.3 мянган төгрөг зарцуулсан нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/480 тоот "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" захирамжийн 2. "Албан ажлын хэрэгцээний автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 50 км-ээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тогтоосугай" заалтыг зөрчсөн байна.

НАГ-ын зөвлөмж

Төсвийн хэмнэлтийн горимыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

Норм, нормативыг хэтрүүлсэн зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх, илүү цагийн хөлсийг төлбөрийн акт тогтоолоо. Цаашид шатахууныг норм нормативын дагуу зарцуулах.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

2015 оны 3 дугаар сарын 19-ны 84 тоот албан бичгийн хавсралтаар ирсэн Нийслэлийн төр захиргааны автобаазын албан тоотыг үндэслэн ажлын бус цагаар суудлын автомашин ашигласаны илүү цагийн хөлс 956.3 мянган төгрөгийн зөрчлийг хасав. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

2015.03.17

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

2015.03.17

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Н.БАТТОГОО

2015.03.17

Байгууллагаас ирүүлсэн санал



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 15, Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны IV байр
Утас/Факс: 7012-8687
http://www.tourism.ub.gov.mn
E-mail: info@tourism.ub.gov.mn

2015.03.19 № 84
танай 2015.03.17 -ны № 354 -т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ОЧИРБАТ ТАНАА

Т. Сэрэншүлэг
Ц. Очирбат
23/III

Захидлын хариу хүргүүлэх тухай

Тус газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн тухай менежментийн захидалтай танилцлаа. Менежментийн захидалд дурдсан зөвлөмжийг мөрдөж, эрсдлийг бууруулж ажиллахаа үүгээр илэрхийлж байна.


Тус газар нь дүрмээр хүлээсэн үүргийнхээ дагуу 2014 онд нийт 189 нэгж ажлыг хариуцан хэрэгжүүлсэн ба ажлын дийлэнхийг нэгдсэн удирдамж, захирамжийн дагуу хот орчмын бүсэд, уртасгасан цагаар, амралтын өдрүүдэд зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, түүний бэлтгэлтэй холбоотой ажлууд эзэлж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор ажлын бус цагаар автомашин ашиглах, тогтоосон хязгаараас /50 км/ давах тохиолдол гардаг.

2015 онд Нийслэлийн төр захиргааны авто баазтай байгуулах гэрээний нөхцөлийг уян хатан болгож, зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллах болно.

Нийслэлийн төр захиргааны авто баазаас авсан тодруулгыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Э.БАТТУЛГА

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
НИЙТ ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	5,257,349.01	8,521,594.00
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,000.01	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	1,000.00	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	0.01	-
БАРАА МАТЕРИАЛ	5,256,349.00	8,521,594.00
Түүхий эд материал	249,000.00	-
Хангамжийн материал	5,007,349.00	8,521,594.00
Бичиг хэргийн материал	3,419,525.00	3,941,402.00
Аж ахуйн материал	1,233,444.00	1,233,444.00
Сэлбэг хэрэгсэл	-	176,000.00
Бусад (хуучин: Бусад хангамжийн материал)	354,380.00	3,170,748.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,257,349.01	8,521,594.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	29,927,485.93	35,721,952.20
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,927,485.93	35,721,952.20
Биет хөрөнгө	29,251,652.65	35,371,952.05
Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,592,715.64	16,405,171.86
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	32,729,546.00	42,668,836.00
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(22,136,830.36)	(26,263,664.14)
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,858,937.01	16,766,780.19
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	26,022,400.00	29,817,400.00
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(10,163,462.99)	(13,050,619.81)
Бусад үндсэн хөрөнгө	2,800,000.00	2,200,000.00
Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(800,000.00)
Биет бус хөрөнгө	675,833.28	350,000.15
Програм хангамж	675,833.28	350,000.15
Програм хангамж - Анхны өртөг	1,950,000.00	1,950,000.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(1,274,166.72)	(1,599,999.85)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	29,927,485.93	35,721,952.20
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	35,184,834.94	44,243,546.20
Түлш халаалтын тооцоо	773,020.00	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧ	-	-
Засгийн газрын сан	60,000,000.00	60,000,000.00
Хуримтлагдсан үр дүн	(25,588,185.06)	(15,756,453.80)
Өмнөх үеийн үр дүн	(25,588,185.06)	(25,588,185.06)
Тайлант үеийн үр дүн	-	9,831,731.26
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	34,411,814.94	44,243,546.20
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	35,184,834.94	44,243,546.20

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	/төгрөгөөр	
БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	222,757,500.00	218,146,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	222,757,500.00	218,146,500.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,751,257.26	161,613,188.26
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	30,751,257.26	161,613,188.26
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	30,751,257.26	160,600,930.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	1,012,258.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	253,508,757.26	379,759,688.26
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	124,437,806.21	159,748,484.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	111,544,231.00	143,440,155.00
Үндсэн цалин	88,914,433.00	107,365,755.00
Нэмэгдэл цалин	11,009,998.00	22,522,000.00
Унаа, хоолны хөнгөлөлт	11,619,800.00	13,552,400.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	12,893,575.21	16,308,329.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,602,931.21	13,403,914.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,282,023.00	10,459,314.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	946,519.21	1,195,351.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,145,324.00	1,457,707.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	229,065.00	291,542.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,290,644.00	2,904,415.00
УРСГАЛ ЗАРДАЛ	105,834,960.27	205,571,572.22
Бусад бараа үйлчилгээний зардал	72,983,930.27	54,388,753.96
Бичиг хэргийн зардал	5,912,043.00	9,284,833.00
Тээвэр, шатахуун	8,316,059.00	7,785,801.00
Шуудан, харилцаа холбоо	4,686,167.36	4,385,498.23
Дотоод албан томилот	881,600.00	958,500.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	167,130.00	165,240.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	995,000.00	-
Төлбөр хураамж, жижиг татварууд	5,793,772.20	8,495,573.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,266,999.00	12,161,940.00
Маягт хэвлүүлэх зардал	4,051,135.00	2,187,545.00
Урсгал засвар	22,214,000.00	1,024,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,700,024.71	7,939,823.73
Хөтөлбөр арга хэмжээний зардал	32,851,030.00	151,182,818.26
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	30,851,030.00	151,182,818.26
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	5,216,230.00	2,204,000.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	25,634,800.00	147,966,560.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	-	1,012,258.26
Төсвийн хуваарилагдаагүй зардал	2,000,000.00	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	28,526,502.90	2,627,159.04
Нэг удаагийн тэтгэмж	8,521,478.00	1,980,741.74

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	267,320,747.38	369,927,957.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮРДҮН	(13,811,990.12)	9,831,731.26

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	223,815,005.00	218,146,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	222,757,500.00	218,146,500.00
НДС-ийн шилжүүлэг	1,057,505.00	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,751,257.26	161,613,188.26
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	30,751,257.26	161,613,188.26
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	30,751,257.26	160,600,930.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	1,012,258.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	254,566,262.26	379,759,688.26
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	124,437,806.21	159,743,484.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	111,544,234.10	143,435,156.00
Үндсэн цалин	85,058,560.10	107,862,956.00
Бусад нэмэгдлүүд	14,865,874.00	22,522,000.00
Бусад нэмэгдэл	14,865,874.00	22,522,000.00
Унаа, хоолны хөнгөлөлт	11,619,800.00	13,050,200.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	12,893,572.11	16,308,328.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,602,929.89	13,403,912.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,282,022.67	10,496,512.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	939,421.89	1,163,000.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,145,322.61	1,453,700.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	236,162.72	290,700.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,290,642.22	2,904,416.00
УРСГАЛ ЗАРДАЛ	95,380,675.56	201,670,713.49
Бараа үйлчилгээний урсгал зардал	62,154,635.56	48,861,215.23
Бусад бараа үйлчилгээний зардал	62,154,635.56	48,861,215.23
Бичиг хэргийн зардал	6,731,930.00	10,304,535.00
Тээвэр, шатахуун	7,493,539.00	8,049,121.00
Шуудан, харилцаа холбоо	4,495,667.36	4,451,498.23
Дотоод албан томилолт	881,600.00	958,500.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	167,130.00	165,240.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	995,000.00	-
Жижиг эд хогшил худалдан авах	659,998.00	1,045,388.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	5,465,772.20	8,495,573.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,199,999.00	12,161,940.00
Маягт хэвлүүлэх зардал	850,000.00	2,029,420.00
Урсгал засвар	22,214,000.00	1,200,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	33,226,040.00	152,808,798.26
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	-	1,550,000.00

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

УИХ болон ИТХ-д суудалтай намд олгох санхүүгийн дэмжлэг	5,216,230.00	-
Бусад төвлөрсөн арга хэмжээ	27,634,800.00	150,246,540.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	375,010.00	1,012,258.26
Төвлөрүүлэх шилжүүлэг	28,526,502.90	2,627,159.04
Нэг удаагийн тэтгэмж	9,527,973.00	1,985,741.74
Бусад	1,057,505.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫНДҮН	257,872,957.67	366,026,398.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,306,695.41)	13,733,289.99
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	16,879,490.00	13,734,290.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	16,879,490.00	13,734,290.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(16,879,490.00)	(13,734,290.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(20,186,185.41)	(1,000.01)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,187,185.42	1,000.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,000.01	(0.00)

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,000,000.00	-	(25,588,185.06)	34,411,814.94
Тайлант үеийн үр дүн	-	-	9,831,731.26	9,831,731.26
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,000,000.00	-	(15,756,453.80)	44,243,546.20

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү /+илүү, -дутуу/	Гүйцэтгэлийн хувь Хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	218,146,500.00	215,545,340.97	(2,601,159.03)	98.81
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	218,146,500.00	215,545,340.97	(2,601,159.03)	98.81
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	218,146,500.00	215,545,340.97	(2,601,159.03)	98.81
Бараа ажил үйлчилгээний зардал	218,146,500.00	215,545,340.97	(2,601,159.03)	98.81
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	144,875,400.00	143,435,156.00	(1,440,244.00)	99.01
Үндсэн цалин	131,807,400.00	130,384,956.00	(1,422,444.00)	98.92
Гэрээт ажлын цалин	13,068,000.00	13,050,200.00	(17,800.00)	99.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,491,100.00	16,308,328.00	(182,772.00)	98.89
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	13,583,600.00	13,403,912.00	(179,688.00)	98.68

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2014 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Тэтгэврийн даатгал	10,676,200.00	10,496,512.00	(179,688.00)	98.32
Тэтгэмжийн даатгал	1,163,000.00	1,163,000.00	-	100.00
ҮОМШ өвчний даатгал	1,453,700.00	1,453,700.00	-	100.00
Ажилгүйдлын даатгал	290,700.00	290,700.00	-	100.00
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	2,907,500.00	2,904,416.00	(3,084.00)	99.89
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	54,780,000.00	53,816,115.23	(963,884.77)	98.24
Бичиг хэргийн материал	10,380,000.00	10,304,535.00	(75,465.00)	99.27
Тээвэр, шатахууны зардал	8,050,000.00	8,049,121.00	(879.00)	99.99
Шуудан холбооны зардал	4,500,000.00	4,451,498.23	(48,501.77)	98.92
Дотоод томилолтын зардал	1,000,000.00	958,500.00	(41,500.00)	95.85
Ном , хэвлэлийн зардал	200,000.00	165,240.00	(34,760.00)	82.62
Жижиг эд хогшил худалдан авах зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	8,500,000.00	8,495,573.00	(4,427.00)	99.95
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,200,000.00	12,161,940.00	(38,060.00)	99.69
Маягт хэвлүүлэх зардал	2,450,000.00	2,029,420.00	(420,580.00)	82.83
Урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
Бусад зардал	3,800,000.00	3,500,288.00	(299,712.00)	92.11
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,985,741.74	(14,258.26)	99.29
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,985,741.74	(14,258.26)	99.29
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	218,146,500.00	215,544,340.96	(2,602,159.04)	98.81
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,000.00	25,000.00	#DIV/0!
Төсвөөс санхүүжих	218,146,500.00	215,519,340.96	(2,627,159.04)	98.80
Байгууллагын тоо	1.00	1.00	-	100.00
Ажиллагсад бүгд	18.00	18.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.00